



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/272

Мандалговь

Эд хөрөнгө түр хариуцагчаар
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 26 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэрэн сумын "Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээ орон нутгийн өмчит газар"-ын эд хөрөнгө түр хариуцагчаар Ч.Батболдыг 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Баярсайхан (Хууль эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: М.Гэрэлмаа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Э.Эрдэнэтунгалаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Л.Амартүвшин (Дэрэн сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Л.Дарьбум (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

3. Эд хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгслэлийг нэг бүрчлэн үзэж акт үйлдэн 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдөр хүлээлцэхийг ажлын хэсэг (Л.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

48121002